



..... СУМЫН
СОНГУУЛИЙН ХОРОО-Д

СУХБААТАРАЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2024.08.08 № 451

танай _____ -ны № _____ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, ТЕЗ-ийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Ардын намын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Мөрийн хөтөлбөр (..... хуудас)-ийг хавсаргав.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ДАВАА

**СҮХБААТАР АЙМГИЙН ОНГОН СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД ХҮРГЭХ ХҮНИЙ
ХӨПЖЛИЙН БОДЛОГО

2217144021
гурван ожилд 358 хувийн

1.1. Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй эхний зээлийн хүүтэй, ипотекийн зээлийн 6 хувийн хүүтэй хөтөлбөрт сумын иргэдийг хамруулах.

1.2. “Миний ажилтан орон сууцтай” хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчид болон иргэдэд зориулж 10 айлын орон сууц барьж, түрээслэх, түрээслээд өмчлөх, ипотекийн зээлд хамруулах.

1.3. Гадаад, дотоодод бэлтгэн сургах 3000 эмч, 10000 сувилагч, 500 мэргэшсэн асрахийн ажилтан бэлтгэх хөтөлбөрт сумын эмч, сувилагч, иргэдийг хамруулах.

1.4. “Элэг бүтэн Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Умайн хүзүүн хавдаргүй Монгол” хөтөлбөрт үзлэгүүдэд сумын иргэдийг хамруулах.

1.5. Эрүүл мэндийн яаралтай тусламжид шаардлагатай техник хэрэгслээр сумын эмнэлэгийг хангуулах.

1.6. Сумын хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэнэ.

1.7. Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.

1.8. Сургуульд байгалийн ухаан, технолгийн хичээлийн лаборатори, туршилтын талбай байгуулна.

1.9. Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

1.10. Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарааны бизнес эхлүүлж байгаа иргэдэд дэмжлэг үзүүлж, нөхцлийг бүрдүүлж ажиллана.

1.11. Ахмадын өргөөнд засвар, өргөтгөл хийж, зориулалтын дагуу ашиглуулан, ахмад настануудын хөдөлмөр эрхэлтийг дэмжин, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагыг залуучуудад өвлүүлж үлдээх нөхцлийг бүрдүүлнэ.

1.12. Зудад өртсөн малчдыг малжуулах ажлыг төрөөс авч хэрэгжүүлж байгаа ажиллагаатай уялдуулан зохион байгуулж, бүрэн хамруулах.

1.13. Зудын эрсдлийг даван туулах “ӨВӨЛЖӨӨ” төсөлд малчдыгэргэн хамруулах.

1.14. Зорилтот бүлгийн иргэдийг “Халамжаас хөдөлмөрт” хамруулан ажилд зуучлан, зөвлөн туслаж, ур чадвар эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.

1.16. Сумын соёлын төвийн шинэ байрыг барьж ашиглалтанд оруулах бүхий л боломжийг ашиглаж ажиллана.

1.17. Сумын соёлын өвийн баялаг байдлыг олон талт агуулгаар баяжуулж, хамгаалан, улс, аймаг, орон нутагт сурталчилан таниулах олон талт ажлыг зохион байгуулж, сумын музей байгуулах.

1.18. Идэвхитэй хөдөлгөөн, спортоор хичээллэгсэдийн идэвхи, санаачлагыг өрнүүлэх олон талт ажлыг зохион байгуулж, дэмжиж ажиллах.

1.19. Сумын иргэдийн бие баялдараа хөгжүүлж, чийрэгжүүлэх орчин үеийн техник хэрэгсэлээр тоноглосон танхимыг байгуулж, ашиглах.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

- 2.1. Эдийн засгийн сэргэлт, хөдөлмөр эрхэлтийг дэмжсэн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.
- 2.2. Суурьшлын бүсийн эрчим хүчний 04 -ийн шугамын өргөтгөл хийж дэд станцын тоог нэмэгдүүлж, хүчин чадлыг нэмэгдүүлэх.
- 2.3. Гурван хонгор, Будрын чуллуу, Таван толгой, Шартын хад чиглэлийн аялал жуулчлалын маршрут гарган, эко аялал жуулчлалын бааз байгуулах.
- 2.4. Адуучин тэмцээнийг жил бүр зохион байгуулж, нутгийн адууны уdam угшилыг сурталчилах.
- 2.5. Шинэ хоршоо хөдөлгөөнийг сурталчилан, суманд **уйл ажиллагааг явуулж** байгаа болон, шинээр байгуулагдаж байгаа хоршооны үйл ажиллагааг дэмжиж ажиллана. **2217144021
ЛЧА00425054561**
- 2.6. Малчдыг хоршоолох замаар мах, сүү, арьс, шир худалдан борлуулах цех байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.7. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйн салбар болгон хөгжүүлнэ.
- 2.8. Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг зохион байгуулж, хэрэгжүүлнэ.
- 2.9. Малын үйлдэр угсаа, чанарыг сайжруулах ажлыг хувийн хэвшилийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 2.10. Малын тэжээлийн ургамал тариалах ажлыг нэмэгдүүлж, байгалийн хадлан бэлтгэж, өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх ажлыг иргэн, хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулна.
- 2.11. Малын тоо толгойн албан татварын зарцуулалтыг ард иргэдэд ил тод болгоно.
- 2.12. Туслах аж ахуй эрхлэх иргэд, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжинэ.
- 2.13. Бороо, цас, гадаргын усыг хуримтлуулж, жижиг нуур цөөрмүүдийг байгуулж, бэлчээрийн даацыг нэмэгдүүлнэ.
- 2.16. Хүлэмжийн тариалалт хийх иргэдийг дэмжиж, нарийн ногоогоор сумын иргэдийг хангах ажлыг зохион байгуулна.
- 2.17. Цэцэрлэг сургуулийн үдийн хоолонд сүү сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлж, малчдын орлогыг нэмэгдүүлнэ.

ГУРАВ. ХӨГХЛИЙГ ХӨТЛӨХ ХУВИЙН ХЭВШИЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ РЕФОРМ

- 3.1. Хүү багатай зээлд сумын иргэдийг хамруулж, жижиг дунд бичил бизнесийг дэмжин ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 3.2. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэдэг иргэдийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжинэ.

ДӨРӨВ. ШУДРАГА ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛ

- 4.1. Цахим орчин дахь ялгаварлал гадуурхал, хүчирхийлэлгүй сум болох аяныг өрнүүлж ажиллана.
- Хэвлэлийн эрх ба иргэдийн мэдэх эрх
- 4.2. Багийн хурлыг улирал бүр, сумын төвийн иргэдэд мэдээлэл хүргэж, санал хүсэлтийг сонсох ажлыг сар бүр зохион байгуулах.
- 4.3. Багш эмч, төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.

4.4. Төрийн албан хаагч нь улс төрөөс ангид, дарамтгүй ажлаа хийх боломжийг бурдүүлнэ.

ТАВ. ШИНЖЛЭХ УХААН, ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ, ХИЙМЭЛ ОЮУН УХААН, ИХ ӨГӨГДӨЛД СУУРИЛСАН ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН ДАХИН ИНЖЕНЕРЧЛЭЛ

5.1. Төрийн албан хаагч нь ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй, намын харьялалаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг хэрэгжүүлнэ.

ЗУРГАА. ХҮН БА ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧИН

6.1. Бэлчээрт хөнөөл учруулж байгаа царцаа, үлийн цагаан огтоно гэх мэрэгч амьтадтай байгаль орчин ээлтэй аргаар тэмцэнэ

6.2. Хүн малын үндны усны эхийг хамгаалаж, хүнсний зориулалтаар ашиглаж байгаа усыг шинжилгээнд оруулж байх.

6.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж, айл өрх, байгууллага бүр мод тариалах ажлыг зохион байгуулна.

6.4. Эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технолги бүхий амины болон нийтийн орон сууц барих иргэдийн санаачлагыг дэмжинэ.

6.5. Хог хаягдалыг дахин боловсруулах, байгальд сөрөг нөлөөлөлгүй аргаар устгах жижиг дунд үйлвэрлэлийн төслийг нэвтрүүлж, дэмжинэ.

ДОЛОО. ХОТ ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРИЙГХАНГАХ БУСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

7.1. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх бүх талын арга хэмжээг авч, хэрэгжүүлнэ.

7.2. Айл өрх, албан байгууллагуудыг цэвэр, бохирын нэгдсэн шугамд холбох

7.3. Авто тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоол, үйлчилгээний төв байгуулах.

7.4. Ёспол хүндэтгэлийн өргөө байгуулах

7.5. Хөдөлмөрийн баатар Р.Гомбын нэрэмжит төв талбай байгуулах.

7.6. Шар бүрдний багийг жишиг баг болгон тохижуулах.

7.7. Сумын төвд сайжруулсан шороон зам тавьж, тэмдэгжүүлэлт, гэрэлтүүлэг хийх.

7.8. Нутгийн зөвлөлийн санаачлагаар байгуулж байгаа цэцэрлэгт хүрээлэнгийн ажлыг дуусган ашиглалтад оруулах.

НАЙМ. ҮНДЭСНИЙ СӨРӨН ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХ БА ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

8.1. Сумын нутаг дэвсгэрт байрлаж байгаа батлан хамгаалах чиглэлийн байгуулагуудтай хамтран ажиллана.

8.2. Сум орноос цэргийн албанд татагдсан залуучуудад тухайн алба хааж байгаа батлан хамгаалах байгууллагатай хамтран мэргэжлийн боловсрол олгох ажлыг зохион байгуулна.

8.3. Цэргийн албыг дүйцүүлэн хаах журмыг мөрдөж, алба хааж байгаа иргэдийг сум орон нутгийн бүтээн байгуулалтанд оролцуулахажлыг зохион байгуулна.

8.4. Сумын байгууллага, ард иргэдийг гамшигийн эрэсдэлтэй нөхцөлд ажиллах арга ажиллагаанд сурган дадлагажуулах.

8.5. Байгаль цаг агаарын аюултай үзэгдлийн мэдээллийг иргэдэд хүргэх ажлыг

шуурхай болгон урьдчилан сэргийлж ажиллах.

8.6. Сумын төвд эрүүл аюулгүй орчныг бий болгох зорилгоор камерын нэгдсэн системд бүрэн шилжүүлнэ.

СҮХБААТАР АЙМГИЙН ОНГОН СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

